

ОРЧИН ҮЕИЙН ДИПЛОМАТ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРЧ БУЙ ШИНЭ ХАНДЛАГА, ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ МОНГОЛ УЛСЫН ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНД ТУСГАХ НЬ

Н. Алтанцэцэг*

Олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлттэй уялдан түүнийг зохицуулах арга механизм буюу дипломат ажиллагаа цар хүрээгээ тэлж, шинэ агуулга, хэлбэр, арга барилаар тодорхойлогдох болж байна. Олон зуун жилийн түүхтэй дипломат ажиллагаа хөгжлийнхөө явцад өөрийн гэсэн онол, практикаар баяжигдан, дипломат ажиллагаа, түүний арга барилын хувьсал, өөрчлөлт, шинэчлэл, хөгжил нь шинжлэх ухааны дүгнэлт, тодорхойлолтыг улам бүр шаардаж байна. Дипломат ажиллагааны арга барил нь даяршлагдан буй дэлхийн улс төр, эдийн засгийн өөрчлөлт, соёл, иргэншлийн ялгаа, улс үндэстнээ хадгалж үлдэх хүчин чармайлт нэг талаас, нөгөө талаас хүн төрлөхтний нийтлэг эрх ашгийг хамтарч хамгаалах, хамтдаа хөгжихийн төлөөх нөхцөл байдалд зохицон уялдах шаардлагатай болж байна.

Дипломат ажиллагаа гэж чухам юуг хэлээд байна вэ гэдэг асуултанд улс төрчид, дипломатууд, эрдэмтэн судлаачид олон янзаар хариулсан нь бий. Дипломат ажиллагаа хэр боловсронгуй болно түүнд өгч буй тодорхойлолтууд төдийчинээ төгөлдөр болж иржээ. Оросын нэрт хуульч, олон улсын харилцаа судлаач Ф.Мартенс “дипломат ажиллагаа бол улс орны гадаад харилцаа, гадаад хэргийн тухай шинжлэх ухаан буюу улс түмний ашиг сонирхлыг харилцан зохицуулах ур чадвар, бүр нарийн утгаараа бол яриа хэлэлцээ явуулах шинжлэх ухаан, ур чадвар мөн”¹ гэж тодорхойлсон байна. Оросын дипломат толь бичигт “дипломат ажиллагаа бол улс орны гадаад бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, түүнчлэн улс орны эрх ашиг, сонирхлыг хилийн чанадад хамгаалахад чиглэгдсэн төр, засгийн газрын тэргүүн, гадаад харилцааны тусгай байгуулагуудын зарчмын үйл ажиллагаа мөн”² гэж тодорхойлжээ. Английн Оксфордын толь “Дипломат ажиллагаа гэдэг бол улс хоорондын харилцааг яриа хэлэлцээний аргаар явуулах, эдгээр

* МУИС, ОУХС-ийн захирал, профессор, доктор

¹ В.И. Попов. Орчин үеийн дипломат ажиллагаа. Онол, практикийн асуудал. УБ., 2007, тал 13-14

² Дипломатический словарь. М., 1971

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

харилцааг элчин сайд, элч төлөөлөгч нараар дамжуулан зохицуулах арга, дипломатчийн ажил буюу ур, чадвар мөн”³ гэжээ.

Орчин цагийн дипломат ажиллагаа зөвхөн улс төрийн харилцааг энхийн замаар хөгжүүлэхэд чиглэгдээд зогсохгүй эдийн засаг, нийгэм, олон нийтийн харилцааг хөгжүүлэхэд чиглэгдэн өргөн цар хүрээг хамрах болж байна. Иймээс дипломат ажиллагааг дотор нь үйл ажиллагааных нь чиглэлээр ангилан үзэж байна. Өнөө үед улс төрийн дипломат үйл ажиллагаа, эдийн засгийн дипломат үйл ажиллагаа, соёлын дипломат үйл ажиллагаа, олон нийтийн буюу ардын дипломат үйл ажиллагаа, эрүүл мэндийн дипломат үйл ажиллагаа, сүйрлээс хамгаалах дипломат ажиллагаа гэх мэтчилэн ангилж байна. Гэвч улс орон бүр гадаад бодлогын цар хүрээ, гадаад харилцааныхаа онцлогоос хамааран өөрийн эрх ашигт илүү нийцэх дипломат ажиллагааг чухалчлан үзэж хэрэгжүүлэх нь зүйн хэрэг. Монгол улсын хувьд зах зээлийн нийгэм, ардчиллын замд шилжин орсноор олон тулгуурт, нээлттэй гадаад харилцааг хөгжүүлж гадаад бодлогынхоо үзэл баримтлалыг тодорхойлоод эдүгээ арван дөрвөн жил болж байна. Гадаад бодлого, гадаад харилцаа бүхэлдээ урьд өмнө байгаагүйгээр өргөжин хөгжиж, Монгол улс ч хоёр талын болон, олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож эхэллээ. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд хоёр хөрштэйгээ харилцах харилцааг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж байгаа нь манай дипломат ажиллагааны ололттой тал мөнөөс мөн. Хөршүүдтэйгээ хоёр талын нягт харилцаагаа хөгжүүлэхэд тэвчиж хандах, цаг зарах, холбоо байгуулах явдал бол дипломат ажиллагааны чадавхийн түлхүүр⁴ гэж гадаад харилцааны мэрэгжилтэн, судлаачид (Wilhelm Schturtz) дүгнэж үздэг.

Манай гадаад бодлогын бас нэг ололттой тал бол бид ямар ч улстай хөрш орны хувьд ч, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд ч улс төрийн, хил хязгаарын болон ямар нэгэн маргаан, зөрчилгүй гадаад бодлогоо зохицуулж ирсэн явдал юм. Гэвч өнөөдрийн олон улсын харилцааны шинэ нөхцөл байдалд бидэнд гадаад харилцаагаа нэгдүгээрт, улс орныхоо хөгжил цэцэглэл, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн Монгол улсын эрх ашгийг хамгаалсан, хоёрдугаарт дэлхийн даяаршилтай холбогдон урган гарч буй дэлхий нийтийн чанартай эрх ашгийг харилцан хамгаалахад дипломат ажиллагааг чиглүүлэх шаардлага гарч ирж байна.

Эдийн засгийн дипломат үйл ажиллагаа

³ Oxford English Dictionary.

⁴ 32 nd International Forum on Diplomatic Training, Vienna, 23-26 June 2004

Монгол улсын эдийн засгийн гадаад харилцаа уламжлалт худалдааны харилцаанаас гадны хөрөнө оруулалт, хувь нийлүүлсэн компани, олон улсын эдийн засгийн байгууллагуудтай хамтарч ажиллах шинэ нөхцөл байдалд хөгжих болж байна. Орчин үеийн гадаад харилцаанд эдийн засгийн үр өгөөжтэй дипломат ажиллагаа явуулах шаардлагатай байгаа бөгөөд энэ нь өөрийн орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдэх ёстой. Үүнд бид Хятадын дипломат ажиллагааг жишээ болгон дурьдах нь зүйтэй гэж үзэж байна. Хятад улс зах зээлийн эдийн засагт бусад социалист орнуудаас хамгийн түрүүнд шилжсэн орон. Гэхдээ дотоод улс төрийн байдлыг тогтвортой байлгаж, эдийн засгийн гадаад харилцаагаа Хятад улсын хөгжил рүү чиглүүлэхэд гол анхаарлаа хандуулж хэрэгжүүлж чадсан. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахдаа Хятадад ашигтайгаар шийдвэрлэж чадсан. Ганцхан жишээ дурьдахад гадаадын хөрөнгө оруулалтыг тодорхой нэгэн /олон биш/ үйлдвэр, район дээр туршаад оруулсан хөрөнгийг нь зөвхөн тэр үйлдвэрт биш тухайн үйлдвэрийн /онцгой бүсийн/ дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхэд зарцуулахаар тохиролцож, Хятадын нийгэм эдийн засгийн хөгжилд ашигтай эсэхийг нь туршин, хэрэв Хятадад ашигтай гэж үзвэл бусад үйлдвэр, хот, районуудад хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлж ирсэн явдал юм. Иймээс тэд эдийн засгийн онцгой бүс, хот гэсэн нэр томъёог гаргаж тэр бүсийг гадаадын хөрөнгө оруулалтаар цогцоор нь хөгжүүлэх бодлого баримталж хөгжүүлж чадсан. Гадныхан хөрөнгөө аваад гарахад Хятад улс олон мянган хүнийг ажиллуулах ажлын байртай, тухайн хөрөнгө оруулсан үйлдвэр болон бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлж, нийгмийн асуудлыг давхар шийдвэрлэж, хөрөнгө оруулалтыг хоёр талд ашигтай байх тооцоог хийж хэрэгжүүлж чадсан туршлагатай улс. Өөрөөр хэлбэл гадаадын хөрөнгийг Хятадад ашигтай зүйлд тооцоотой, бодлоготой зарцуулж чадсан.

Орчин үед эдийн засгийн болон бизнесийн дипломат үйл ажиллагаа олон улсын харилцаанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болж байна. Худалдааны дипломат ажиллагаа олон жилийн турш явагдаж ирсэн боловч өнөөгийн бүс нутгийн интеграцчилал, даяаршлын үед зөвхөн засгийн газар хоорондын үйл ажиллагаанаас хүрээгээ хальж, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн байгууллага, холбоо, нэгтгэл, компаниудын хооронд өргөжин хөгжих боллоо. Энэ нөхцөлд бизнесийн бүлэглэлүүд, худалдаа, хөрөнгө оруулалтын стратегийн төвүүд ГХЯ-тай уялдаатай ажиллах шаардлагатай байна. Үндэсний болон үндэстэн дамнасан корпорацтай санал бодлоо солилцож харилцан хамтарч ажиллах төлөвлөгөө боловсруулах хэрэг гарч байна.

Бизнес дипломат албаны хэрэглээ болж байна. Нөгөөтэйгүүр бизнес дипломат үйл ажиллагааг хангагч нь болж байна. Ашгийнхаа төлөө явж байгаа бизнесийн харилцаа холбоо дипломат ажиллагааны чиглүүлэгч нь болж байна.

Элчин сайдын яамдууд түүний дотор Элчин сайдууд өндөр дээд хэмжээний уулзалт, айлчлал зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэхээс гадна тухайн орон болон бүс нутгийн зах зээлийн талаарх мэдлэгтэй, судалгаатай, оновчтой санал гаргадаг байх шаардлагатай байна. ГХЯ нь Сангийн Яам, Худалдаа, Аж үйлдвэрийн Яам, Түлш, Эрчим хүчний Яам, Хөдөө Аж Ахуйн Яамдтай хөндлөн харилцаа тогтоож, эдгээр яамдуудын гадаад харилцааны салбар дахь хүчин чармайлтыг зохицуулж, холбоо харилцааг нь хөнгөвчилж өгөх, бизнесийн хоорондын болон засгийн газрын зохих байгууллагуудтай урт хугацааны тогтвортой харилцааг тогтоох явдалд туслахад гол үүрэг гүйцэтгэх ёстой. Засгийн газар болон бизнесийн бүлгүүд бие биенээ дэмжин, улсын болон хувийн секторууд, яамд хоорондын өрсөлдөөнийг саад тотгоргүй явуулахад тусламж дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай байна.

Олон улсын эдийн засгийн амьдралыг дотоодын бизнес холбоонууд болон иргэдийн аж ахуйн нэгжтэй холбож, тэдэнд тайлбарлан таниулах, судалгаа, сургалтын үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна. Орон нутаг, бүс нутаг, дэлхийн эдийн засаг болон олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг мэдэх, түүнд суралцах, практик үйл ажиллагаа өөрөөр хэлбэл эдийн засгийн дипломат үйл ажиллагаа явуулах мэргэжлийн чадавхийг ахиулах шаардлагатай байна..

Нийгмийн дипломат үйл ажиллагаа

Орчин үеийн дипломат үйл ажиллагаанд нийгмийн дипломат ажиллагаа тодорхой байр суурийг эзэлж байна. Нийгмийн дипломат ажиллагаа гэж юуг хэлээд байна вэ гэдэг асуултанд хариулахын тулд зарим нэгэн жишээ татаж тайлбарлая. Өнөөдөр дэлхийн цаг агаарын өөрчлөлтөөс болж хүмүүний нийгэмд учирч буй гамшигууд хүмүүсийн анхаарлыг ихэд татаж байна. Цөлжилт, дулаарлаас болж үүсч буй байгалийн өөрчлөлтүүд, агаарын бохирдол, гал түймэр, үер, халдварт өвчин, салхи шороон шуурга гэх мэт. Эдгээр сөрөг үзэгдлүүдэд Засгийн газрууд үйл ажиллагаагаа хамтарч чиглүүлэх, олон улсын аюулгүй байдлыг хангахад олон нийтийн оролцоо, боломжийг ашиглах болж байгаа юм.

Одоо үед шинээр хөгжиж байгаа орнуудад үйлдвэрлэл хурдацтай хөгжих болсон нь тэднийг энэ үйл ажиллагаанд улам идэвхтэй оролцуулах болж байна. Энэтхэг, Хятад зэрэг хүн ам олонтой хөгжиж байгаа орнуудад үйлдвэрлэл хөгжих болсноор тэд эдийн засгийн, байгалийн болон хүний аюулгүй байдлыг хамгаалах дипломат үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтарч ажиллах, харилцан хариуцлага хүлээх шаардлагатай болж байна.

Монгол орны хувьд ч бид дэлхийн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, түүнд иргэний нийгэм, олон нийтийн оролцоог улам бүр идэвхжүүлэх шаардлагатай байна. Манай улсын иргэд, иргэний хөдөлгөөнүүд уул уурхайн салбарт гадны хөрөнгө оруулах болсонтой холбогдон гарч ирж буй асуудлуудыг Монгол улсад ашигтай байх зарчмыг баримталж үйл ажиллагаа явуулахыг шаардсанаар засгийн газрын шийдвэр гаргалтанд нөлөөлж чадаж байна. Энэ нөхцөлд дипломат ажиллагаа нь олон нийтийн дуу хоолойг сонсдог, тэдний санал бодлыг харгалзан үйл ажиллагаандаа тусгадаг байх шаардлага гарч байна. Дэлхийн хүн амын талаас илүү хувийг эзлэх хөгжиж буй орнууд үйлдвэрлэл хөгжүүлэх болсонтой холбогдон хүн төрлөхтөнд учрах хор, хөнөөл, уршигийг тооцоолж, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад дипломат аргыг хэрэглэх болж байгаа юм. Дипломат үйл ажиллагаанд бизнес, санхүү, газар тариалан, үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд гээд нийгмийн олон салбар оролцох болсон. Тэд өөр өөрсдийн чиглэлээр хамтарсан үйл ажиллагаа явуулах арга механизмыг хэрэглэх өөрөөр хэлбэл олон улсын яриа, хэлэлцээ хийх, санал солилцож, боловсруулж, шийдвэр гаргахад нөлөөлөх, хэрэгжүүлэхэд оролцох, хяналт тавих шаардлагатай болж байгаа юм.

Сүйрлээс хамгаалах, зохицуулах дипломат үйл ажиллагаа

Дэлхий нийтийн шинжтэй сүйрэл терроризм, хорлон сүйтгэх ажиллагаа, эмх замбараагүй үймээн, хар тамхины наймаа, хил дамнасан зэвсгийн наймаа зэрэг нь дипломат төлөөлөгчдийн газрын хариуцлага, сонор сэрэмжийг өндөршүүлэх, түргэн шуурхай, уян хатан, гэнэтийн сүйрлээс хамгаалах бүтэц, систем, төлөвлөгөөтэй байхыг шаардаж байна. Сүйрэл, хор хөнөөл учруулж болзошгүй, хорлон сүйтгэх үйл хэргийг маш шуурхай мэдэрч байх, дипломат постуудыг хурдан шуурхай, үр бүтээлтэй ажиллах боломжоор хангаж, туслаж байх, мэдээллийг хурдан шуурхай хүргэж байх, шийдвэр гаргах, зохицуулах систем, бүтцийг хөнгөвчлөх, түргэн тусламжийг цаг тухайд хүргэж байх, мэдээллийн технологи, харилцаа холбоог ашиглаж байхад анхаарах хэрэгтэй болж байна гэж дэлхийн хэмжээнд мэдэгдэж анхааруулж байна.

Дипломат албаны хүмүүст энэ талаар сургалт явуулах хүн бүрийн оролцоо, үүрэг хариуцлага, хөдөлмөрийн хуваарийг оновчтой, харилцан уялдаатай байх ажил үүргийн холбоог тодорхой болгож байх шаардлагатай тулгарч байна. Ерөнхий командын төвийн шийдвэр гаргах, түүнийг биелүүлэх үйл ажиллагааг баг болон хувь хүмүүстэй холбох холбоо, гүйцэтгэлийг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна. Мөргөлдөөн гарч буй газрыг нэмэгдэл хүчээр хангах, хохирол гарсан газар тусламж үзүүлэх зэрэг практик ажиллагааг шуурхай явуулахад

идэвхтэй оролцох чадварыг өндөржүүлэхийг олон улсын дипломат ажиллагааны нийтлэг шаардлага болгон тавьж байна. Сүйрлийг зохицуулах үйл ажиллагааны бүтэц, хамтын ажиллагааг сайжруулахад шийдвэр гаргалт, төлөвлөгөөг практиктай холбох, газар дээр нь хэрхэн хэрэгжүүлэхийг мэддэг байх, гүйцэтгэж чаддаг байх чадварыг эзэмшүүлэхэд анхаарахыг мөн чухалчлан тавьж байна.

Иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах дипломат ажиллагаа.

Дипломат ажиллагааг дипломат алба гүйцэлдүүлдэг. Дипломат алба гадаад бодлогыг гүйцэлдүүлдэг төдийгүй түүнийг боловсруулахад оролцож эцэст нь улс орныхоо ашиг сонирхлыг хамгаалахаар барахгүй түүний иргэд, хилийн чанадад амьдарч буй хүн нэг бүрийнхээ ашиг сонирхлыг хамгаалах зорилтыг биелүүлж байдаг гэж Оросын дипломатч, профессор В.И.Попов тодорхойлсон байдаг. Үүнд бүхэлдээ ГХЯ, ЭСЯ, Ерөнхий консулын болон Консулын газруудын ажлыг хамтруулан дүгнэжээ. В.И.Попов “Дипломат ажиллагааны гол зорилт бол улс орныхоо болон түүний иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах явдал юм”⁵ гэж дүгнэсэн байдаг.

Монгол орны хувьд цөөхөн тоотой монголчуудын аюулгүй байдал, амьд явах эрх, эрүүл мэндийг хамгаалахад дипломат алба, хариуцсан яам агентлагуудын ажлын уялдаа холбоо, хариуцлагыг зохих түвшинд гаргах шаардлагатай байна. Гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн газар монгол иргэдийн эрх ашгийг тэр бүр хамгаалж чадахгүй, зарим нь эрх үүргээ ухамсарладаггүй, мэддэггүйн улмаас яваад очиход тээршээсэн байдалтай ханддаг хүнд суртлыг арилгах, монгол иргэдийн төлөө санаа тавьж ажилладаг, тэдний эрх ашгийг сайтар хамгаалдаг байх шаардлагатай байна.

Өнөөдөр монгол охид бүсгүйчүүд харийнханд худалдагдаж, бэлгийн дарамтанд орж байгаа нь нууц биш. Энэ талаар дотоодын зохих байгууллагууд, гадаадад суугаа дипломат төлөөлөгчдийн газар сонор сэрэмжтэй, хамтарч ажиллаж, арга хэмжээ авах цаг нэгэнт болсон.

Мөн гадаадад амьдарч байгаа монгол иргэдийн эрх ашиг зөрчигдөж буйд санаа тавьж, тэдний эрх ашгийг хамгаалахад ЭСЯ, Консулын газар идэвхтэй ажиллах шаардлагатай байна. Ганцхан жишээ дурьдахад АНУ, Европын орнууд, ер нь гадаадад амьдарч байгаа монголчуудын дунд “хараар амьдрах” гэдэг ойлголт нэгэнт бий болж, хэл мэдэхгүй, тухайн орны нөхцөл байдалд зохицож ажиллаж чадахгүй монголчууд хулгай хийж амьдарч, хэрэг төвөгт орооцолдож, монгол

⁵ В.И Попов. Дурьдсан зохиол, тал 14

хүний нэр хүндийг унагааж буй нь энүүхэнд болсон. Нэр хүнд унана гэхээсээ илүү гадаадад амьдарч байгаа зарим монголчуудын ажиллах, хүн шиг амьдрах эрх зөрчигдөж байгаа нь харамсал төрүүлж байна. Гадаадын олон оронд монголчууд цагдаа, хүчний байгууллагаас айн нуугдан амьдарч, хэд хэд дахин баригдаж, нутагтаа хөөгдөж ирсэн нь монгол залуучуудын дунд “баатарлаг гавъяа” байгуулсан мэт яригдах болжээ. Гадаадад амьдарч буй монголчуудын нэр хүнд унаснаас болж монголчууд хоорондоо нийлдэггүй, бие биенээсээ зугтаадаг, аль болохоор монгол хүн монгол хүнээс хол байхыг боддог. Элчин сайдын яамдууд болон Консулын газраас зугтаах, мэдэгдэхгүй байхыг хичээдэг. Энэ нөхцөлд монголчууд маань гадаадад хэрхэн амьдарч юу хийж яваад анхаарах цаг болсон. Гадаадад монголчуудын нэр хүнд унасан нь гадаад орнуудын бүх гааль монголчуудын паспортыг “гоц” анхаарч шалгадаг болсноор ч илэрхийлэгддэг. Гадаадад амьдарч буй монголчуудын эрх ашгийг хамгаалахад Монголын дипломат төлөөлөгчийн газрууд, консулын ажилтнууд илүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дэлхий нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн дипломат үйл ажиллагаа

Дипломат үйл ажиллагаа нь аливаа улс орны эрх ашгийг хамгаалахад юуны өмнө чиглэгддэг бөгөөд даяаршлын үед түүний зэрэгцээгээр дэлхий нийтийн эрх ашгийг хамтарч хамгаалахад чиглэгдэх болж байна. Аливаа улс орны дотоодын хөгжлийн асуудал, нийгмийн асуудал, байгаль орчны асуудал, аюулгүй байдлын асуудлууд ч дэлхийн хамтын хүчин чармайлтаас хамааралтай болж байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи А.Аннан хэлэхдээ: “Дэлхий нийтийн шинжтэй зүйлд улс орнууд төдийлэн анхаарал тавьдаггүй. Гэвч даяаршил улс орнуудыг үндсээр нь харилцан хамааралтай болгож, дэлхийн шинжтэй зүйлд анхааран, хамтарч ажиллахад хүргэж байна”⁶ гэж онцлон хэлж байсан. Өнөөдөр ямар нэгэн их гүрэн дангаараа дэлхийн олон улсыг хамарсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй бөгөөд үүнд дэлхийн олон орныг татан оролцуулж хамтран ажиллах механизм бүрдүүлж байна. Дэлхийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, байгаль орчны бохирдол, сүйрлийг хамгаалах, халдварт өвчнөөс хамгаалах, түүнтэй хамтарч тэмцэх, хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах гээд дагаж мөрдөх олон улсын хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжүүлэх зэрэг шинэ өргөн далайцтай ажлууд хийгдэж байна.

Хил дамнасан асуудлуудыг шийдвэрлэхэд уламжлалт гэрээ, хэлэлцээрүүд хийх ажил чухал бөгөөд өнөөдөр гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж чадах вэ гэдэгт ихээхэн ач холбогдол

⁶ *Providing Global Public Goods. Managing globalization. New York, Oxford, Oxford University Press, 2003, p. iii*

өгдөг болж байна. Даяаршлагдаж байгаа өнөө үед олон улсын чанартай “эд хөрөнгө”-ийг хариуцах хариуцлага чухал болж байна. “Олон улсын эд хөрөнгө”-ийг харилцан ашиглахын тулд үйлдвэрлэдэг, бүтээн байгуулдаг. Манайд хамгийн ойр жишээ болгон хий дамжуулах хоолой тавих асуудлыг авч үзье. Хий дамжуулах хоолой тавих асуудал зөвхөн үйлдвэрийн асуудал биш, зөвхөн олон улсын гэрээний асуудал биш, хамгийн гол нь гэрээгээ биелүүлэх чадавхи, хариуцлагын асуудал юм. Бид хоёр хөршөө манай улсыг тойруулан хийн хоолой татаж байна, биднийг хавчиж байна гэж хэлж хардах, бас ч буруушаах дуртай. Гэвч бидний зах зээлийн, эдийн засгийн, үйлдвэрийн, инженерийн эцсийн эцэст хариуцлагын чадавхи юу билээ гэдгийг анхааран үзэж, гадаад оронтой ажиллах ажлын үүрэг болон хариуцлагыг өндөршүүлэх шаардлагатай байгаа юм. Бид хоёр хөршөөс онцгой анхаарч үзэхийг гуйдаг, хоёр хөрш биднийг “харж үздэг”, “өгөөмөр сэтгэл гаргадаг” гэдэг ухамсраас ангижирч, харилцан тэгш эрх, тэгш үүрэг, хариуцлага шаардсан дипломат ажиллагаа явуулахад анхаарах цаг нэгэнт болжээ.

Дэлхийн харилцааны өөрчлөлтэй холбогдон бодлого боловсруулах процесс өөрчлөгдөх нь

Олон улсын харилцааны судлаачид дэлхийн харилцаа, түүнийг зохицуулах үйл явцыг судалж шинэ шинэ санаа, дүгнэлтүүдийг хийж байна. Олон улсын харилцааг гүйцэлдүүлэхэд Элчин сайдуудын томилгоо чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Уламжлал ёсоор олон улсын харилцаа нь орон, бүс нутгийн харилцааг газар зүйн байршлаар нь ангилж зохион байгуулж ирсэн. Ялангуяа улс орнуудын эдийн засгийн харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд газар зүйн байршилд ихээхэн ач холбогдол өгдөг. Гэвч сүүлийн үед дэлхий нийтийг хамарсан шинжтэй асуудлууд газар зүйн байршлаас үл хамааран нийгмийн олон салбарт хамтран анхааран ажиллахыг шаардаж байна. Үүний тулд олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарч, түүнд идэвхтэй оролцох явдал чухал болж байна. Үүнтэй уялдуулж шийдвэр гаргах нөхцөл байдалд ч өөрчлөлт орж байна. Дэлхий нийтийн шинжтэй байгаль орчин, олон улсын худалдаа, санхүүгийн гэх мэтчилэн асуудлыг шийдвэрлэхэд дэлхийн, хамтын шийдвэр хэрэгтэй болж байна. Зарим оронд дэлхийн шинжтэй асуудлыг зохицуулах тусгай яам, агентлагууд байгуулагдан ажиллаж байна. Жишээ нь Францад Тогтвортой хөгжлийн яам, Шведийн Төрийн нарийн бичгийн дарга дэлхийн банканд хувь эзэмшигчдийн асуудлыг хариуцаж байна. Иймэрхүү зохион байгуулалт нь тухайн орноос дэлхийн шинжтэй асуудалд бодлогоор оролцох эрх мэдэл, хариуцлагыг өндөршүүлж, дэлхийн шинжтэй асуудлыг эх орондоо шийдвэрлэхэд үр бүтээлтэй нөлөө үзүүлж байна.

Олон улсын санхүү, худалдаа зэрэг нь дэлхийн бодлогын хүрээнд зохицуулагдаж байна. Хойшид ч дэлхийн шинжтэй асуудлуудад улс орон татагдан оролцох хандлага улам бүр ихсэж байна. Энэ нөхцөлд ГХЯ-ны асуудал эрхэлсэн газар, хэлтсийн үйл ажиллагааг дэлхийн бодлоготой хэрхэн холбох вэ гэдэг асуудал гарч ирж байна. Иймээс дотоодын бодлогыг гадагш хэрэгжүүлэх, дэлхийн чанартай бодлогыг дотоодын олон нийтийн тоглогчидтой холбох явдлыг зохион байгуулах асуудал гарч ирж байгаа юм.

Юуны өмнө ГХЯ бусад яамдуудын газар, хэлтэстэй ажлаа хорших, зохицуулах хөндлөн холбоог эрчимжүүлэх явдал улам бүр чухал болж байна. ГХЯ-ны улс болон бүс нутгийн тухай мэдлэг, туршлагыг тодорхой асуудлаарх практик улс төрчдийн агентлагуудын мэрэгжлийн туршлага мэдлэгтэй холбох шаардлага гарч ирж байна. Мөн төрийн бус байгууллагууд, иргэд улс орны эрх ашгийг хамгаалах асуудалд хүчтэй оролцох болсноор тэдний санал бодлыг сонсдог, хүлээж авдаг механизмыг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Голландын ГХЯ -ны харъяа Клингендалийн Институтын гаргасан судалгаагаар дэлхий нийтийн асуудалтай холбоотой асуудалд төрөлжсөн яамдуудын газрын үүрэг ихэнх хувийг эзэлж ГХЯ дэмжих үүрэгтэй байхад бүс орон нутгийн харилцааны асуудлаар ГХЯ гол үүрэг гүйцэтгэж бусад яамдууд дэмжих үүрэгтэй оролцож байна гэж дүгнэсэн байна. Шинээр гарч ирж буй бодит асуудлуудтай уялдан гадаад бодлогын шийдвэр гаргах процесст зохицуулалт хийгдэж байна. Бодлого боловсруулах хөдөлгүүрүүдийг шинэ нөхцөл байдалд уялдуулан хөдөлгөх шаардлага гарч байна. Гадаад бодлогын шийдвэрт ч шинэчлэл, өөрчлөлт хийх, шинэ дипломат үйл ажиллагаа явуулах саналууд олонтаа гарч ирж байна.⁷

Соёлын дипломат ажиллагаа

Орчин үед олон улсын харилцаанд соёлын дипломат ажиллагаа эрчимтэй явагдаж байна. Судлаачдын үзэж байгаагаар соёл иргэншил устана гэхээсээ соёл устана гэдэгт санаа зовинож, соёлоо хамгаалах, авч үлдэх оролдлого ихсэж байна. Иймээс соёлоо авч үлдэх аливаа хүчин чармайлтыг дэмжих явдал дипломат ажиллагааны нэг зорилго бөгөөд үүний тулд яриа хэлэлцээний арга замыг ашиглан зохицуулах хэрэгтэй байна гэж үзэж байна. Нөгөө талаас дэлхий дээр соёлын иерархи тогтоох, төв болох гэсэн оролдлого хүчирхэг соёлтой орнуудын дунд байнга явагдаж байна. (Alfred Pfabigan)

⁷ Riordan, Shaun. *The new Diplomacy*. Cambridge; Polity Book 2003; Cooper, Andrew, John English and Thakur. *Enhancing Global Governance: Towards a New Diplomacy?* Tokyo: United Nations University Press. 2002

Монгол улс Азийн болон нүүдлийн соёл иргэншилтэй. Гэвч даяршлын эрин үед бидний хэл, соёл, бусад улс үндэстний хэл соёлд автагдах магадлал өндөр байгаад манай эрдэмтэд, судлаачид анхаарч бодол саналаа бишгүй хэлж байгаа. Хэл, соёлоо хамгаалах цогц бодлого явуулах цаг нэгэнт болсон. Одоогийн залуучууд монгол хэл, соёл гэхээсээ хятадын, японы, солонгосын, америкийн хэл, соёлыг илүүд үзэж түүнд суралцах боллоо. Зарим эрдэмтэд таван зуун жилийн дотор монгол хэл устана гэсэн тооцоо гаргасан нь бий. Гадаадын орнууд монгол залуучуудад тэтгэлэг өгч, Монголд өөрсдийн хэл, соёлын сургалт судалгааны ажлыг явуулж өөрийн хэл, соёлд сургах сурталчлах ажлыг эрчимтэй хийж байна. Энэ бол гадныхны алсын хараатай “агуу” дипломат ажиллагаа. Үүнийг орчин үеийн дипломат ажиллагаанд “зөөлөн дипломат ажиллагаа” ч гэж нэрлэдэг. Монгол улс зөвхөн олон улсын улс төр, эдийн засгийн геостратегийн сонирхлыг татаад зогсоогүй, олон орны соёлын өрсөлдөөний талбар болж байна. Өнөө үед бид зөвхөн гадны соёлыг хүлээн авагч, “сурагч” нь болоод байгаа нь манайх соёлын дипломат ажиллагаандаа ялагдал хүлээж, алдаа гаргаж байгаагийн илрэл мөн. Дипломат ажиллагаа нь ямар ч нөхцөлд уужуу тайван ухаарал, зөв тактик, тэсвэр хатуужил шаарддаг бөгөөд үүнд биеийн алжаалыг үл умартан ажиллахдаа алдаа гаргах ёсгүй гэж Бэн Франклин (Ben Franklin) тодорхойлсон байдаг.

Дипломат ажиллагааны хөгжлийн чиг, хандлага

Дипломат ажиллагаа, олон улсын харилцааны судалгаа харьцангуй шинэ салбар шинжлэх ухаан бөгөөд өөрийнхөө хөгжлийн хурд, хувьслаар олон улсын судлаачид, эрдэмтэд, улс төрчид, дипломатуудын анхаарлыг улам бүр татаж байна. Дипломат ажиллагаа нь нийтлэг шинжийг агуулахаас гадна улс орны онцлог, үндэсний шинжийг бас агуулан хөгжиж ирсэн. Тив бүс нутгаар нь авч үзвэл Европын орнуудын дипломат ажиллагаа сонгодог түүхтэй. Гэвч Европынхон Азийн орнуудын дипломат ажиллагааг бас илүүтэй хүндэтгэн үзэх явдал ч байна. Дипломат ажиллагаа улс төрийн ажил учир олон улсын улс төрийн харилцаа, тэмцэл, хамтрал, сөргөлдөөн түүнд заавал нөлөөлдөг. Мэдээллийн эрин үед дипломат ажиллагаанд аналитик мэдээлэл ихээхэн ашиглах болж байна. Олон улсын харилцаанд түншлэлийн харилцаа өргөн явагдаж байна. Дипломат ажиллагаа түншүүдийн итгэлцэлд тулгуурласан байр суурийг агуулж байна. Итгэлцэл нь илэн далангүй байдал ил тод байдалд тулгуурласан, үүний үндсэн дээр харилцан ойлголцож, зөвшилцсөн харилцааг шаардаж байна. Харанхуйгаар итгэхгүйн тулд түншийн тухай өргөн мэдлэг, түүний улс төрийн бодлого, олон улсын харилцааны байр суурийг сайтар мэдэж, дүн шинжилгээтэй байх

явдал нэн түрүүнд шаардлагатай байна. Дипломат албанд бодлогын Төв аппарат доороосоо дээш гаргах саналыг дэмждэг болсон. Төвөөс өгсөн үүрэг даалгаврыг газар дээр нь хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл гол үүрэг гүйцэтгэгчид урьд шугаманд ажиллаж Төвийн ажлыг хөнгөвчлөх хэрэгтэй болж байна (Mars Grossman).

Зарим судлаачид Элчин сайдын яамдууд улс төрийн бодлогын хамгийн анхны шинжлэх ухааны задлан шинжилгээ хийдэг газар гэж үздэг. Урьдын адил мэдээллийг нууцлах, хулгайлах явдал хоцрогдож итгэлцээний үндсэн дээр үнэн зөв мэдээлэл олж авах аргад шилжиж байна. Өргөн мэдээлэл, мэдлэгтэй болсон өнөө үед дипломат ажиллагаанд худлаа ярих, хууран мэхлэх ажиллагаа үеэ өнгөрөөж, дипломат ур чадварын тэргүүн зэрэгт оюун ухаан, уян хатан чанар, итгэл найдварыг тавьдаг болж байна. Итгэл найдварт тулгуурласан хэлэлцээ хийх явдлыг орчин үеийн дипломат ажиллагаа илүү шаардах болж байна. Даяаршлын үеийн дэлхийн олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлт, чиг хандлагыг харгалзан үзэж зарим судлаачид дараах дүгнэлтийг хийж байна.

Английн Дипломатын Академийн багш, дипломатч Алан Хенриксоны (Alan Henrikson) үзэж байгаагаар Дипломат ажиллагаанд таван боломжийн ирээдүй байна. Нэг. Disintermediation буюу хувь хүний харилцаа, хамтын ажиллагааны дипломат үйл ажиллагаа (өрнөдийн дипломат ажиллагаанд дипломатч хувь хүний идэвх, чадавхийг илүү үнэлдэг),

Хоёр. Europeanisation буюу улс үндэстнүүдийг бүсчлэх,

Гурав. Democratisation буюу олон талт зөвлөлгөөн, ихэвчлэн оюун ухааны итгэл найдвараар шийдвэрлэгддэг,

Дөрөв. Thematisation буюу газар орноос хамааралгүй асуудалд анхаарч, элчин яамдуудын хийх ажил эрдэм шинжилгээний хуралд шахагдах,

Тав. Americanisation буюу олон нийтийн дипломат ажиллагаа, лобби, уламжлалт биш каналуудаар нөлөөлөх.⁸

Алан Хенриксон дэлхийн хэмжээний сонгодог дипломат ажиллагааны хөгжлийг ерөнхийд нь авч үзэн дүгнэсэн байна.

Орчин үед дэлхий нийтийн шинжтэй асуудлууд олноор гарч, хөгжиж байгаа орнууд эдийн засгийн хувьд хүчирхэгжиж, олон улсын харилцаанд татагдан орох болсноор дипломат үйл ажиллагааг дэлхий нийтээр баримталдаг нийтлэг зарчимд оруулан хөгжүүлэхэд илүү анхаарах болж байна. Судлаач Часик, Пажамани нарын үзэж байгаагаар “хөгжиж байгаа олон оронд

⁸ 32 nd Internatioanal Forum on Diplomatic Training. Conference material. Vienna. 23-26 June 2004

дипломат үйл ажиллагааны үндэсний чадавхи сул байгаагаас олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахад гэрээ, хэлэлцээрийн ур чадвар үгүйлэгдэж байдаг”⁹-ийг онцолсон байна.

Манай орны хувьд ч Монголын дипломат ажиллагааны ур чадварыг дээшлүүлэх, дипломат ажиллагаа, олон улсын харилцааны сургалт судалгааг дэлхийн түвшинд явуулах шаардлагатай байна. МУИС-ийн ОУХС Их сургуулийн түвшний сургалт явуулдаг бөгөөд манай оронд ГХЯ-ны дэргэд бие даасан, дипломатууд болон гадаадад ажиллах хүмүүст зориулсан сургалтын албан ёсны төвтэй болж энэ төвийн үйл ажиллагааг дэлхийн Дипломат сургалтын төвтэй холбож, Монголын дипломат ажиллагааг дэлхийн дипломат ажиллагааны хөгжилтэй уялдуулах шаардлагатай байна.

⁹ *Providing Global Public Goods. Managing globalization. New York, Oxford, Oxford University Press, 2003, p., 46*